



# ЭЗХАХБ-ын Үндэстэн дамнасан компанийн удирдамж

Хариуцлагатай бизнесийн үйл ажиллагааны  
гарын авлага



# ЭЗХАХБ-ын Үндэстэн дамнасан компанийн удирдамжийн тухай

ЭЗХАХБ-ын Үндэстэн дамнасан компанийн удирдамж ('цаашид Удирдамж гэх') дэлхийн аль өнцөгт явуулж буй бизнесийн үйл ажиллагаандаа хариуцлагатай хандахыг зөвлөсөн засгийн газруудын дэмжлэгтэй зөвлөмжүүд юм. Удирдамж нь хүний эрх, ажил эрхлэлт, байгаль орчин, мэдээллийн ил тод байдал, авилгал, татвар зэрэг өргөн хүрээний асуудлуудад хамаардаг. Удирдамжийн Маргаан шийдвэрлэх механизм нь бизнесийн зөрчлийг арилгахад чиглэсэн өвөрмөц хэрэгсэл юм. Энэхүү гарын авлага нь Удирдамж болон түүний Гомдлын механизмыг танилцуулах зорилготой.

## Удирдамжийн үндсэн заалтуудын танилцуулга

### Оршил

Удирдамж нь сайн дураар мөрдөх стандарт ба зарчмуудаас бүрдэх боловч Удирдамжийг хэрэгжүүлэгч орнууд зөвлөмжүүдийг *зайлшгүй хэрэгжүүлэх үүрэг* авсан байдаг

### Бүлэг I • Үзэл баримтлал ба Зарчмууд

Удирдамж нь эдийн засгийн бүх салбар болон дэлхий дахина үйл ажиллагаа явуулж буй ЭЗХАХБ-ын гишүүн ба хэрэгжүүлэгч орнуудын үндэстэн дамнасан компанийн бүх үйл ажиллагаанд хамаарна.

### Бүлэг II • Ерөнхий бодлого

Компаниуд нь үндэсний хууль тогтоомжийн хүрээнд тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах байдлаар ажиллана. Тэд өөрийн үйл ажиллагаанаас учирч болзошгүй бүхий л сөрөг нөлөөллийг үнэлэх (зохистой ажиллагаа – due diligence - ба бусад үнэлгээнүүд), урьдчилан сэргийлэх, нөлөөллийг бууруулах үйл ажиллагааг бизнесийн бүх харилцаа, үйлдвэрлэлийн бүх шатанд хэрэгжүүлэх үүрэгтэй. Компаниуд өөрийн үйл ажиллагаанд сонирхол бүхий бүх талуудтай бодитойгоор зөвлөлдөж, компанийн засаглалын өндөр зарчим баримтлаж улс төрд зохисгүйгээр оролцохоос татгалгазана.

### Бүлэг III • Мэдүүлэг, мэдээллийн ил тод байдал

Компанийн өөрийн үйл ажиллагаанд холбогдох бүтэц, санхүү ба санхүүгийн бус (нийгэм ба байгаль орчин г.м.) үзүүлэлтүүд, өмчлөл болон засаглалын ач холбогдол бүхий мэдээллийг нийтэд нээлттэй байлгана. Компаниуд бизнесийн харилцаа, үйл ажиллагаа, тэдгээрийн нөлөөллийн талаарх мэдээллийг нийтэд нээлттэй байлгана.

#### **Бүлэг IV • Хүний эрх**

Компаниуд хүний эрхийг үйл ажиллагаандаа болон бодлогын хүрээнд хүндэтгэнэ. Хүний эрхийн эрсдлийн үнэлгээ хийж бодит болон болзошгүй нөлөөллийг шийдвэрлэж, зөрчигдсөн эрхийг сэргээх механизм бурдуулсан байна.

#### **Бүлэг V • Хөдөлмөр ба үйлдвэрлэлийн харилцаа**

Компаниуд хөдөлмөрийн үндсэн стандартуудыг хүндэтгэж ажиллагсдад зохистой ажлын байр, ба тэдний гэр бүлийн наад захын хэрэгцээг хангах цалин хөлс олгоно.

#### **Бүлэг VI • Байгаль орчин**

Компаниуд байгаль орчин ба нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдлалд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг тогтоох, урьдчилан сэргийлэх ба нөлөөллийг бууруулах үүрэгтэй. Байгаль орчны менежементийн тогтолцоо бий болгох, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаагаа байнга сайжруулах, түүнчлэн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулна.

#### **Бүлэг VII • А: Авилга ба авилгал**

Компаниуд бусдад шууд болон шууд бусаар авилга өгөхгүй мөн авахгүй байх үүрэгтэй. Авилгалыг тогтоох, урьдчилан сэргийлэх ёс зүйн ба нийцлийн хөтөлбөртэй, дотоод хяналтын тогтолцоотой байх үүрэгтэй. Авилгалтай тэмцэхэд чиглүүлж буй хүчин чармайлтын талаар ил тод тунгалаг байна.

#### **Бүлэг VIII • Хэрэглэгчийн ашиг сонирхол**

Компаниуд борлуулалт ба маркетингийн шудрага практик хэрэгжүүлэх: өөрийн бараа үйлчилгээний чанар ба найдвартай байдлыг хангах; өөрийн бараа, үйлчилгээний тухай тодорхой, нотлогдохуйц болон ойлгомжтой мэдээллийг хэрэглэгчид өгч зөв сонголт хийхэд нь дэмжих үүрэгтэй.

#### **Бүлэг IX • Шинжлэх ухаан ба технологи**

Компаниуд шинэ технологийн ноу-хау шилжүүлэх, оюуны өмчийн эрхийг ашиглуулах болон нутгийн иргэдийг ажиллуулах замаар орон нутгийн болон үндэсний инновацийн чадавхыг хөгжүүлнэ.

#### **Бүлэг X • Өрсөлдөөн**

Компаниуд өрсөлдөөнийг зохицуулах хуулийн зохицуулалтанд нийцэж, өрсөлдөөнийг хаах байдлаар авирлахаас татгалзана.

#### **Бүлэг XI • Татвар**

Компаниуд хууль ба зохицуулалтыг ягштал биелүүлж, цаг тухайд нь татвараа төлж, үйл ажиллагаа явуулж буй орныхоо нийтийн \төрийн\ санхүүгийн салбарт хувь нэмэр оруулна. Мөн татвар төлөх үүргээс зайлсхийх зорилгоор ашиг ба алдагдлыг шийлжүүлэхээс татгалзана.

## Гомдол хэрхэн мэдүүлэх

Энэхүү алхам алхмаар удирдах гарын авлагад ЭЗХАХБ-ын Хяналт (OECD Watch) ТББ-аас ИНБ-ууд, бусад байгууллага ба хувь хүмүүс ЭЗХАХБ-ын Удирдамжийг зөрчсөн асуудлаар гомдол гаргах, гомдол барагдуулах зуучлал болон цаашдын алхмуудын талаарх зөвлөлгөө багтсан болно. Нарийн удирдамж авах бол ЭЗХАХБ-ын Хяналтын ЭЗХАХБ-ын Удирдамжийн зааварчилгааг [www.oecdwatch.org](http://www.oecdwatch.org) сайтаас татаж үзнэ үү.

### Гомдол гаргахад бодолцох:

- Зөрчлийг маш тод тодорхойлох, мөн үйлдсэн эсвэл холбогдсон гэж бодож байгаа компаниудыг олж тогтоох
- Удирдамжийн Гомдлын механизмын давуу ба дутадалтай талуудыг харьцуулж үзэх. Өөр стратеги баримтлах нь илүү үр дүнтэй эсвэл шуурхай байх эсэхийг судлах. Зэрэгцүүлэн ашиглаж болох стратеги байж болох г.м. талуудыг бодолцох.
- Гомдлыг хэлэлцэх үйл явцад хүн хүч, санхүүгийн нөөц ба цаг хугацаа шаардагдахыг тооцоолох.

## ЭЗХАХБ-ын Удирдамжинд 2011 онд хийсэн шинэчлэл

2011 оны 5-р сард, ЭЗХАХБ-ын гишүүн ба хэрэгжүүлэгч орнуудын засгийн газруудаас шинэчилсэн ЭЗХАХБ-ын Удирдамжийг баталсан. Хэдийгээр хэрэгжүүлэх механизм байхгүй гэх мэт суурь дутагдлууд оршсон хэвээр байгаа ч шинэчлэлээр зохистой ажиллагаа (due diligence), нийлүүлэлтийн гинжин сүлжээний хариуцлага, хүний эрх ба ҮМН-ийн журам зэргийг сайжруулсан.

**Зохистой ажиллагаа:** Зохистой ажиллагааны үнэлгээ гэдэг нь бодит ба болзошгүй сөрөг нөлөөг олж тогтоохын төлөө идэвхтэй ажиллах, урьдчилан сэргийлэх, бууруулах, сөрөг нөлөөг хэрхэн шийдэж байгааг тайлагнах үйл явц юм. Зохистой ажиллагааны үйл явц нь сөрөг нөлөөллийг үнэлэх; олж тогтоосон зөрчлийг бүртгэх ба шийдвэрлэх; авсан хариу арга хэмжээг бүртгэх, мөн нөлөөллийг хэрхэн шийвэрлэж буй мэдээллийг тгээх үйлдлүүдийг агуулдаг. Удирдамжийн хүрээнд багтсан асуудлуудаар, тухайлбал хүний эрх, хөдөлмөр эрхлэлт, байгаль орчны асуудлаар зохистой ажиллагааны үнэлгээ хийхийг компаниудад үүрэг болгов.

**Нийлүүлэх, туслан гүйцэтгэх гинжин сүлжээ(supply chain)-ний үүрэг:** Удирдамж нь компанийн бүх үйл ажиллагаа, мөн түүний охин компани, туслан гүйцэтгэгч, нийлүүлэгч зэрэг

бизнесийн харилцагч бүт хамаарна. Тэд өөрийн бараа, үйлчилгээгээр сөрөг нөлөөлөл учруулах, хувь нэмэр оруулахаас зайлсхийхээс гадна сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэхийг эрмэлзэх үүрэгтэй.

**Хүний эрх ба талуудтай зөвлөлдөх:** Удирдамж нь үйл ажиллагаа явуулж буй бүх орчинд хүний эрхийг хүндэтгэхийг компаниудад үүрэг болгосон. Мөн хүний эрхийг зөрчих, зөрчихөд хувь нэмэр оруулахаас зайлсхийхийн зэрэгцээ нөлөөлөлд өртсөн талууд, хувь иргэд, нутгийн бүлгүүдтэй бодитой зөвлөлдөх үүрэгтэй.

**Үндэсний мэдээлэх нэгжийн үйл ажиллагаа:** ҮМН нь төвийг сахисан, тодорхой, тэгш шудрага байдлаар гомдлыг шийдвэрлэнэ. Ил тод байдлыг эрхэмлэж, хугацаа тогтоож түүнийг баримтлах, ойлгомжтой тодорхой үйл явцтай, өөрийгөө таниулж бүх талуудад нээлттэй ажиллах үүрэгтэй.

2

### Зохистой ажиллагааны асуултуудад хариулах:

- Танай асуудал ЭЗХАХБ-ын Удирдамжид хамаарах эсэхийг тогтоох. Аль Бүлэг, заалтыг зөрчсөнийг тогтоох.
- Компани ба бусад байгууллагуудын харилцаа, тэдний зөрчилд оролцсон байдлын зураглал гаргах (жишээбэл толгой компани, охин компани, хамтарсан үйлдвэр, санхүүжүүлэгч, гинжин хэлхээсийн түнш, бусад бизнесийн харилцаа).
- Аль Үндэсний Мэдээлэх Нэгж (ҮМН)-д хамаарах ба тэдний гомдол хэлэлцэх дэгийг судалсан байх.

3

### Зорих үр дүнгүүдээ тодорхойлох:

- Компаниас нэхэмжлэх, шаардах зүйлсээ тодорхойлох (жишээбэл: бодлого эсвэл тодорхой практик ажиллагааг өөрчлөх, хохирлоос сэргийлэх эсвэл сөрөг нөлөөллийг нөхөх г.м.).
- ҮМН-ээс юу хүсч байгааг танилцуулах (жишээбэл: эвлэрүүлэн зуучлах, зөрчил баримтжуулах, нийцлийн шалгалт, зөвлөмж дүгнэлт гаргуулах г.м.).
- Зөвшилцөж болох, огт буулт хийж болохгүй асуудлуудаа тодорхойлох.
- Гомдол гаргаснаас учирч болзошгүй бусад эерэг ба сөрөг үр дагаварыг тодорхойлох (засгийн газрын бодлого сайжрах, компанийн практик арга барилд өөрчлөлт орох, мэдээллээр хангадсанаар олон нийтийн мэдлэг дээшлэх г.м.).



## ЭЗХАХБ-ын Үндэсний Мэдээлэх Нэгж

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD) нь 34 орны засгийн газар хоорондын байгууллага болно. Нийгэм ба эдийн засгийн бодлого боловсруулж, хэрэгжилтийг дэмждэг. ЭЗХАХБ-ын Үндэстэн дамнасан компанийн Удирдамжийн бүрэлдэхүүн хэсэгт нь багтах Хөрөнгө Оруулалтын Тунхаглалыг ЭЗХАХБ-ын гишүүн орнуудаас гадна 9 орон хэрэгжүүлдэг.

Удирдамжийг хэрэгжүүлэгч Засгийн газрууд нь Удирдамжийг таниулах болон компанийн зүй бус үйл ажиллагааны “тодорхой тохиолдлын” тухай гомдлыг шийдвэрлэх Үндэсний Мэдээлэх Нэгж байгуулах үүрэгтэй. “Тодорхой тохиолдлын” тухай гомдлын үйл явц нь эвлэрүүлэн зуучлах хэлбэрээр талууд хоорондоо зөвшилцсөн шийдэл олох зорилготой. Зуучлал үр дүнд хүргээгүй тохиолдолд ҮМН нь Удирдамжийн зөрчил

тогтоогдсон эсэх тухай мэдэгдэл хийж Удирдамжийг сахин биелүүлэх тухай зөвлөмж гаргана.

ЭЗХАХБ-ын гишүүн болон гишүүн бус хэрэгжүүлэгч орнууд нэгэн адил бодит үйл ажиллагаа бүхий ҮМН-тэй байгуулах үүрэгтэй. Бүх ҮМН засгийн газрын алба байх боловч зохион байгуулалт ба байршлын хувьд өөр өөр байдаг. Зарим ҮМН нь засгийн газрын нэг байгууллагад байрладаг. Зарим ҮМН нь бизнес, үйлдвэрчин ба ТББ-ын төлөөллийг бүрэлдэхүүн хэсэгт оруулж бүрдсэн олон-талт нэгж хэлбэртэй байдаг. Хөндлөнгийн эксперт эсвэл гаднаас удирдах орон тооны бус удирдах зөвлөлтэй ҮМН-үүд хамгийн үр дүнтэй байх жишээтэй. Бүх ҮМН-д ил тод, хүртээмжтэй, тунгалаг ба тайлагнал бүхий үйл ажиллагаа явуулах шаардлага тавьдаг.

4

**Гомдол бичих:**

ЭЗХАХБ-ын Хяналт ТББ-аас иргэний байгууллагуудад зориулсан маш тодорхой, бүрэн гүйцэд, товч болон итгэл үнэмшилтэй гомдол бичих загвар боловсруулсан. Гомдолд наад зах нь: гомдол гаргагчдын тухай мэдээлэл; гомдлын үндэслэл болсон зөрчил (үүд); компани ба түүний зөрчилд оролцсон, холбогдсон байдал; ЭЗХАХБ-ын Удирдамжийн зөрчигдсөн зүйл заалтууд; зөрчлийг нотлох мэдээлэл; компанид тавьж буй шаардлага\ нэхэмжлэл; ҮМН-ээс авах арга хэмжээг тодорхойлсон хүсэлт.

5

**Гомдол бүртгүүлэх, хэлцэлд оролцох:**

Гомдлыг мэйлээр эсвэл шуудангаар зохих ҮМН-д хүргүүлнэ. ҮМН-ийн гомдлыг хэлцэл үйл явц, дэг нь дараах шатуудас бүрддэг:

- Анхан шатны үнэлгээ: ҮМН гомдлыг судалж үзэх үндэслэлтэй эсэхийг тогтооно. ҮМН-д нэлээд олон удаа нэмэлт мэдээлэл, тодруулга бичиж байх бэлтгэлтэй хангах хэрэгтэй.
- Хэлцэл: ҮМН нь талуудыг харилцан хүлээн зөвшөөрөх шийдэлд хүргэх хэлцлийг зуучилдаг. Хэлцлийн явцад ҮМН болон компанитай эвлэрүүлэх уулзалтуудад оролцох бэлтгэлтэй байх хэрэгтэй.
- Зөрчил тогтоох: Эвлэрүүлэх хэлцэл үр дүнд хүргэхгүй бол ҮМН зөрчлийг тогтоох үнэлгээ хийх шийдвэр гаргадаг.



## Хэн, юун тухай, хэзээ, хаана ба хэнд гомдол гаргах вэ?

ҮМН-үүдийн тогтоосон гомдлын үйл явцын журмууд нэг ҮМН-ээс нөгөөгийн хооронд хол ялгаатай. Гомдлыг боловсруулж мэдүүлэхээс өмнө тухайн ҮМН-ийн журмыг судалж үзэх хэрэгтэй. Харин нийтлэг журамд дараах зүйлүүд багтана:

**Хэн:** Гомдлыг аливаа сонирхогч тал мэдүүлж болно. Эдгээрт ҮЭ ба ТББ, ажилчид, нутгийн иргэд болон компанийн үйл ажиллагааны сөрөг нөлөөлөлд өртсөн хувь хүн ч орно.

**Юун тухай:** ЭЗХАХБ-ын гишүүн эсвэл хэрэгжүүлэгч оронд үйл ажиллагаа явуулж буй эсвэл бүртгэлтэй компанийн дэлхий дахина явуулж буй үйл ажиллагааны нөлөөллийн талаар гомдол гаргаж болно.

**Хэзээ:** Зохистойгоор шийдвэрлэгдээгүй өнгөрсөн хугацааны хохирол, одоо учирч буй хохирол эсвэл компани зохистой ажиллагааны үнэлгээ хийлгүй төлөвлөж хэрэгжүүлснээс бий болж болзошгүй хохирлын талаар гомдол гаргаж болно.

**Хэнд:** Гомдлыг зөрчил бий болсон орны ҮМН-д гаргана. Хэрэв зөрчил гарсан оронд ҮМН байхгүй бол компанийн толгой офис байрлах орны ҮМН –д гаргана. Гомдлыг гомдол гаргагчдын болон компанийн бүртгэлтэй орнуудын ҮМН-дэд нэгэн зэрэг гаргаж болно.

**Ямар зорилготой:** ЭЗХАХБ-ын Удирдамжийн хүрээнд гомдол гаргах нь компанийн үйл ажиллагаа, зан авирт өөрчлөлт оруулах, (баталгаатай биш байх талтай) асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулах, гомдлыг барагдуулах боломж олгодог.

**Эцсийн шийдвэр ба цаашдын үйл явц:**

Гомдлын үйл явцыг хаахдаа ҮМН-ээс эцсийн нийтэд нээлттэй мэдэгдэл гаргадаг.

- Эвлэрүүлэх зуучлал амжилттай болсон бол мэдэгдэлд зөрчлийн асуудлууд, хэлцлийн үйл явц ба эцсийн хамтын шийдвэрийг тусгадаг.
- Эвлэрүүлэх зуучлал амжилтанд хүрээгүй бол мэдэгдэлд зөрчлийн асуудлууд, хэлцлийн үйл явц болон талуудад хандсан зөвлөмжийг тусгадаг. ЭЗХАХБ-

ын Хяналт ТББ ҮМН-ээс гаргах эцсийн мэдэгдэлдээ зөрчлийн үнэлгээг хэрхэн үнэлсэн үйл явцын тухай мэдээллийг мөн тусгахыг хүсдэг.

- Мэдэгдэлд хяналт мониторинг ба цаашид авах арга хэмжээний талаар тохирсон зүйлүүд болон зөвлөмжүүд тусгагдана. Олон баримт бичгийн төсөлд санал өгөх, үг хэллэг дээр хэлцэж мэтгэлцэх бэлтгэлтэй байх хэрэгтэй.

## ЭЗХАХБ-ын Хяналт ТББ (OECD Watch) ба ЭЗХАХБ-ын Удирдамж

ЭЗХАХБ-ын Хяналт ТББ нь бизнесээс тогтвортой хөгжил ба ядуурлыг бууруулах үйлст хувь нэмэр оруулах, компаниуд дэлхийн аль ч өнцөгт өөрийн үйл ажиллагаанд хариуцлага хүлээдэг болгохын төлөө ажилладаг.

OECD Watch нь 45 оронд бизнесүүд тогтвортой хөгжил, ядуурлыг бууруулахад явцад хувь нэмэр оруулдаг, дэлхийн хаан ч үйлдсэн хэргийнх нь төлөө хариуцлага хүлээлгэх зорилго нэгдсэн ТББ-ын глобал сүлжээ юм. Компанийн хариуцлагыг хатуу үүрэгжүүлсэн тогтолцоо глобал хэмжээнд байхгүй орчинд ЭЗХАХБ-ын Удирдамж нь компаниудыг гадаад орнуудад явуулж буй үйл ажиллагаанд нь хариуцлага хүлээлгэдэг цөөхөн хэрэгслүүдийн нэг юм.

**Нөлөөлөл & лобби:** Хүлээн зөвшөөрөгдсөн сонирхогч талын хувьд ЭЗХАХБ-ын Хяналт ТББ нь ИНБ-ууд болон нутгийн бүлгүүдийн дуу хоолой ба байр суурийг ЭЗХАХБ-ын Хөрөнгө оруулалтын хороонд хүргэх дамжуулагчийн үүрэг гүйцэтгэдэг. ЭЗХАХБ-ын Удирдамжийн хэрэгжилт, ҮМН-ийг үйл ажиллагааг сайжруулах мониторингийн ажлын зэрэгцээ ЭЗХАХБ-ын Хяналт ТББ нь олон улсын хөрөнгө оруулалтад, мөн бизнесийн үйл ажиллагаанд хамаарах нийгэм, байгаль орчин, эдийн засгийн өргөн хүрээ бүхий асуудлуудаар бодлогын зөвлөмж гаргадаг.

**Чадавх бэхжүүлэх & дэмжлэг:** ЭЗХАХБ-ын Хяналт ТББ иргэний нийгмийн байгууллагууд ба

нутгийн бүлгүүдийг дараах байдлаар дэмждэг: чадавх бэхжүүлэх семинар; Удирдамж ба түүний Гомдлын механизмын талаар нарийвчилсан зөвлөлгөө өгөх; Удирдамжийг хэрхэн ойлгож хэрэглэх тухай гарын авлага боловсруулж түгээх; болон ИНБ-ууд тус сүлжээний зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг нь дэмждэг.

**Судалгаа & шинжилгээ:** ЭЗХАХБ-ын Хяналт ТББ нь ЭЗХАХБ-ын Удирдамжийн хэрэгжилт, үр бүтээл, нөлөөнийх нь асуудлуудыг судалж дүн шинжилгээ хийдэг. ЭЗХАХБ-ын Удирдамжийн үр өгөөжийг судалж дутагдалтай талуудыг илрүүлснээр энэхүү механизм ба ҮМН бүрийн үйл ажиллагаанд ахиц гарна гэж ЭЗХАХБ-ын Хяналт ТББ итгэдэг. Сүлжээ нь онлайн мэдээллийн сантай бөгөөд улирал тутамд гомдлын кейсүүдийн дүн шинжилгээ, үйл явцын талаар мэдээлэх *Кейсийн Улирлын Мэдээлэл* хэвлэж тараадаг.

**Компанийн хариуцлагын бусад хэрэгслүүд:** ЭЗХАХБ-ын Удирдамжаас гадна ЭЗХАХБ-ын Хяналт ТББ нь дэлхий дахина хэрэглэгдэж буй компанийн хариуцлагын бусад хэрэгслүүдийг сайжруулах нөлөөллийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог.



## Гарын авлагын тухай

Энэхүү гарын авлага нь ЭЗХАХБ-ын Үндэстэн дамнасан компанийн Удирдамж болон түүний Гомдлын механизмын товч танилцуулгаас бүрдэнэ. Бизнесийн хариуцлагагүй үйл ажиллагаанд өртсөн иргэний нийгмийн байгууллагууд, ажилчид, нутгийн бүлгүүд ба хувь хүмүүс энэхүү Удирдамжийг ашиглан компаниудыг өөрийнх нь үйл ажиллагаанд хариуцлага хүлээлгэх боломжтой. Хэрхэн ашиглахыг энэ гарын авлагад тайлбарласан болно.


Нарийвчилсан мэдээллийг ЭЗХАХБ-ын Хяналт ТББ-ын вебсайтаас Үндэстэн дамнасан компаниудын Удирдамжийг хэрхэн ашиглах тухай ЭЗХАХБ-ын Хяналт ТББ-ын удирдамжаас үзнэ үү ([www.oecdwatch.org](http://www.oecdwatch.org)).

## ЭЗХАХБ-ын Хяналт ТББ-ын тухай

2003 онд байгуулагдсан ЭЗХАХБ-ын Хяналт ТББ нь 45 оронд үйл ажиллагаа явуулдаг 80 гаруй ИНБ-гаас бүрдэх глобал сүлжээ болно. Гишүүнчлэлд нь бизнесийн үйл ажиллагаа хөгжил ба ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулж, дэлхийн аль ч өнцөгт компани өөрийн үйл ажиллагаанд хариуцлага хүлээдэг болгохын төлөө зорилго нэгтэй ИНБ-ууд багтдаг.

OECD Watch  
Sarphatistraat 30  
1018 GL Amsterdam  
The Netherlands

+31 20 6391291  
[info@oecdwatch.org](mailto:info@oecdwatch.org)  
[www.oecdwatch.org](http://www.oecdwatch.org)



Энэхүү гарын авлагыг хэвлэлтийг Дани ба Норвегийн Гадаад харилцааны яамдын санхүүгийн дэмжлэгтэй хэрэгжүүлсэн болно. Гарын авлагын эх хувийг ЭЗХАХБ-ын Хяналт ТББ англи хэл дээр үйлдсэн бөгөөд орчуулгыг Оюу Толгойн Хяналт ТББ хариуцаж хийлгэсэн тул орчуулгын зөрүү гарвал ЭЗХАХБ-ын Хяналт ТББ-ын англи хувьтай харьцуулж хэрэглэх эсвэл дээрх хаягуудаар холбоо барьж болно.

2012 оны 6-р сар